

# “МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫГ БҮРТГЭХ, СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГЫГ ТОГТООХ ЖУРАМ”

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоохтой холбогдон үүсэх харилцааг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хүрээнд энэхүү журмаар зохицуулна.

1.2 Журмаар үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд шаардагдах нэгж буюу бүлэг ажилбарыг гүйцэтгэх арга барил, техник, технологийн анхан шатны мэдлэг, чадвар, дадлыг тодорхой ажил мэргэжлийн суурь чадварыг эзэмшүүлэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, дадлагажуулахад чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох богино хугацааны мэргэжлийн сургалт /цаашид “сургалт” гэх/-ыг зохион байгуулах үйл ажиллагааг зохицуулна.

1.3 Энэхүү журмын хүрээнд тодорхой түвшний ур чадвар эзэмшүүлэх, хөдөлмөрийн болон бизнес эрхлэх үндсэн мэдлэг, чадвар олгох, хэл, компьютер, иогийн сургалт эрхлэх байгууллагуудын үйл ажиллагаа хамаарна. Үүнд:

1.3.1 Иргэнд мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх сургалтын төрөлд мэргэжлийн болон техник технологийн суурь чадамж эзэмшүүлэх;

1.3.2 Иргэнд хөдөлмөрийн болон бизнес эрхлэх үндсэн мэдлэг, чадвар эзэмшүүлэх сургалтад хөдөлмөр эрхлэх ур чадвар олгох, аж ахуй, бизнес эрхлэх чадамж олгоход чиглэгдсэн сургалт.

1.4 Энэхүү журмын 3.1-т заасан шаардлагыг ханган бүртгүүлсэн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж /цаашид “мэргэжлийн сургалтын байгууллага” гэх/ зохион байгуулна.

1.5 Шаардлага хангасан мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэж, улсын хэмжээнд нэгдсэн загвар, бүртгэлийн дугаар бүхий гэрчилгээ олгоно.

1.6 Журмын хэрэгжилтийг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв /цаашид “МБСУМАЗТ” гэх/ ханган ажиллана.

1.7 МБСУМАЗТ нь мэргэжлийн сургалтын байгууллагуудын мэдээллийн санг бүрдүүлж, тасралтгүй хөгжүүлнэ.

1.8 Төгсөлтийн үнэлгээг холбогдох журмаар зохицуулна.

## **Хоёр. Мэргэжлийн сургалтын зорилго, хамрах хүрээ**

2.1 Мэргэжлийн сургалтын зорилго нь иргэний авьяас, сонирхол, хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан мэргэжлийн боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн мэргэжлийн суурь ур чадвар, мэргэшүүлэх чадамж эзэмшүүлэхэд оршино.

2.2 Мэргэжлийн сургалтын байгууллага нь өөрийн үйл ажиллагаатай холбогдох энэ журмын 2.2.1-д тусгагдсан салбаруудын хүрээнд мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх чиглэлээр ур чадвар, чадамж эзэмшүүлэх сургалтыг чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрөөр явуулна. Үүнд:

2.2.1 Боловсрол /хэл, сэтгэхүй хөгжүүлэх сургалт/; соёл урлаг; цагдаа, батлан хамгаалах, онцгой байдал; санхүү, бизнес худалдаа; мэдээллийн технологи; шуудан, харилцаа холбоо; байгаль орчин, аялал жуулчлал; барилга; тээвэр; эрчим хүч; уул уурхай; хөдөө аж ахуй; аж үйлдвэр; хот байгуулалт, тохижилт; үйлчилгээний салбарууд хамаарна.

2.3. Төр, сүм хийдийн харилцааг зохицуулах тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу зохион байгуулах шашны болон шашинтай холбогдох зан үйлийн сургалтыг энэхүү журмаар зохицуулахгүй.

### **Гурав. Мэргэжлийн сургалтын байгууллагын үйл ажиллагаанд тавигдах шаардлага**

3.1 Мэргэжлийн сургалт эрхлэх бүртгэлийн гэрчилгээ шинээр авахад дараах бичиг баримтыг бүрдүүлж, МБСҮМАЗТ-д цахимаар хандана. Үүнд:

3.1.1 хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар

3.1.2 хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгааг ажил олгогчийн хэрэгцээнд үндэслэн боловсруулсан байх;

3.1.3. үйл ажиллагаа эрхлэх байршил, хаягийг захирлын тушаалаар баталгаажуулсан байх;

3.1.4 МБСҮМАЗТ-өөр мэргэжлийн сургалтын хөтөлбөрт дүгнэлт гаргуулсан байх;

3.1.5 мэргэжлийн сургалтын төвийн багш нь мэргэжлийн зэрэгтэй, тухайн чиглэлээр 3-аас доошгүй жилийн ажлын дадлага, туршлагатай, мэргэжлийн боловсрол, сургалтын сургах зүйн чадамж эзэмшүүлэх сургалтын хамрагдаж, гэрчилгээ авсан байна.

3.1.6 MNS 6541:2015, Мэргэжлийн, боловсрол, сургалт.Ерөнхий шаардлага” стандарт, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрт заасан сургалтын

орчин, техник хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байх;

3.1.7 өөрийн байранд дадлага хийлгэх боломжгүй тохиолдолд аж ахуйн нэгж, байгууллага үйлдвэрийн газартай гэрээ байгуулж баталгаажуулсан дадлагын сургалт зохион байгуулах боломжийг бүрдүүлсэн байх,

3.1.8 элсэгчдийн болон төгсөгчдийн мэргэжлийн ур чадварын түвшин тогтоох материалыг боловсруулж, захирлын тушаалаар баталгаажуулсан байх;

3.1.9 суралцагчидтай байгуулах гэрээний загварыг боловсруулан гэрээнд сургалтын төлбөрийн хэмжээг тусгасан байх;

3.2 Тээврийн хэрэгслийн болон мэргэшсэн жолооч бэлтгэх сургалтын байгууллагын үйл ажиллагаа эрхлэхээр хүсэлтээ гаргасан /шинээр/ аж ахуйн нэгж байгууллага нь энэхүү журмын 3.1.1-3.1.6 дахь заалтаас гадна дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

3.2.1 Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын байгууллага Ерөнхий шаардлага MNS 6585:2016 стандартын хангасан аж ахуйн нэгж, байгууллага байна.

3.2.2 Мэргэжлийн боловсрол, сургалт ерөнхий шаардлага MNS 6541:2015, Жолооч бэлтгэх сургалтын байгууллагын ерөнхий шаардлага MNS 6585:2016 стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд дүгнэлт гаргасан албан бичиг;

3.2.3 Жолоодлогын дадлагын тээврийн хэрэгсэл түүний нэмэлт тоног төхөөрөмж нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан байх бөгөөд автотээврийн үндэсний төвийн итгэмжлэгдсэн техникийн хяналтын үзлэгийн төвийн техникийн хяналтын үзлэг, оношилгооны дүгнэлт буюу гэрчилгээгээр баталгаажсан баримт бичиг;

3.2.4 Жолоодлогын өөрийн дадлагын талбайгүй сургалтын байгууллага нь ерөнхий шаардлага MNS 6585:2016 стандартад нийцсэн жолоодлогын дадлагын талбайг түрээслэж болно.

3.2.5 Жолоодлогын дадлагын талбайн газрыг ашиглах, эзэмших эрхийг баталгаажуулсан баримт бичиг; /нотариатаар баталгаажуулсан хуулбар/;

3.3 Мэргэжлийн сургалт эрхлэх бүртгэлийн гэрчилгээний хугацаа сунгуулахад дараах бичиг баримтыг бүрдүүлж, МБСҮМАЗТ-д ирүүлнэ. Үүнд:

3.3.1 хугацаа дууссан гэрчилгээний эх хувь;

3.3.2 хүсэлт гаргасан албан бичиг

3.4 Тээврийн хэрэгслийн болон мэргэшсэн жолооч бэлтгэх сургалтын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх хугацаа сунгуулах хүсэлт ирүүлсэн сургалтын байгууллага 3.3.1, 3.3.2 дахь заалтаас гадна дараах бичиг баримтыг ирүүлнэ. Үүнд:

3.4.1 Автотээврийн үндэсний төвийн мэргэшсэн жолоочийн нэгдсэн сангаас нийт төгсөгчдийн мэдээллийн хуулбар;

3.4.2 Цагдаагийн ерөнхий газрын “Бүртгэл хяналтын төв”-өөс суралцагчдыг үнэлсэн үнэлгээний жагсаалт;

#### **Дөрөв: Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, гэрчилгээ олгох**

4.1 Мэргэжлийн сургалтын үйл ажиллагаа шинээр эрхлэх, хугацаа сунгуулах хүсэлтээ тухайн оны 1, 2, 3, 4 дүгээр улирлын эхний сард, МБСҮМАЗТ-д хүргүүлнэ.

4.1.1 Шаардлага хангасан материалыг бүрэн ирүүлсэн хуулийн этгээдэд Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, МБСҮМАЗТ, “Автотээврийн үндэсийн төв”, Цагдаагийн ерөнхий газрын Бүртгэл хяналтын төвийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг, орчин нөхцөлтэй нь танилцаж, тухайн улирлын 2 дахь сард дүгнэлт гаргана.

4.1.2 Шаардлага хангаагүй мэргэжлийн сургалтын байгууллагад хариу мэдэгдэж, материалыг буцаан олгоно.

4.1.3 Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэр гаргаж, холбогдох сайтад байршуулна.

4.1.4 Шаардлага хангасан мэргэжлийн сургалтын байгууллагын бүртгэлийн гэрчилгээг 3, 6, 9, 12 дугаар сард Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

4.1.5 Мэргэжлийн сургалтын байгууллага нь төгсөлтийн үнэлгээнд холбогдох байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, чадамжийн гэрчилгээг МБСҮМАЗТ олгоно.

### **Тав. Мэргэжлийн сургалтын байгууллагын гэрчилгээний хүчинтэй хугацаа, хүчингүй болгох**

5.1 Мэргэжлийн сургалтын байгууллагад олгох гэрчилгээ нь улсын хэмжээнд нэгдсэн загвартай байх, бүртгэлийн он, сар, өдөр, дугаар болон хүчинтэй хугацааг заасан байна.

5.1.1 Мэргэжлийн сургалтын байгууллагад олгох гэрчилгээний дугаар давхцахгүй байна.

5.1.2 Анх удаа хүсэлт гарган, шаардлага хангасан мэргэжлийн сургалтын байгууллагад нэг (1) жилээр, гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусч, эрх сунгах хүсэлт гаргасан шаардлага хангасан мэргэжлийн сургалтын байгууллагын бүртгэлийн гэрчилгээний хүчинтэй хугацаа хоёр (2) жил хүртэл хугацаагаар олгоно.

5.1.3 Мэргэжлийн сургалтын байгууллагын бүртгэлийн гэрчилгээг хаяж үрэгдүүлсэн тохиолдолд холбогдох газарт хүсэлт тавин шийдвэрлүүлнэ.

5.1.4 Мэргэжлийн сургалтын байгууллагад тавигдах шаардлагыг зөрчсөн, хууль бус үйлдэл гаргасан тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

5.1.5 Мэргэжлийн сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг хангаагүй, бүртгэлийн гэрчилгээний хугацаа дууссан, сунгалт хийгдээгүй сургалтын үйл ажиллагаа явуулж, хуурамч бичиг баримт олгосон хуулийн этгээдийн сургалт явуулах эрхийг түдгэлзүүлж, бүртгэлийн гэрчилгээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.

### **Зургаа: Тайлан мэдээ**

6.1 Мэргэжлийн сургалтын байгууллагын үйл ажиллагаанд Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, МБСҮМАЗТ удирдлага, арга зүйн зөвлөгөө өгч, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран хяналт тавьж ажиллана.

6.2 Жолооны сургалтын байгууллагыг 3 жилд 1 удаа мэргэжлийн боловсрол, сургалтын болон Зам тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, МБСҮМАЗТ, “Автотээврийн үндэсний төв” төрийн

өмчит үйлдвэрийн газар, Цагдаагийн ерөнхий газрын Бүртгэл хяналтын төв, мэргэжлийн холбоодтой хамтран хяналт шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт гаргана.

6.3 МБСУМАЗТ нь мэргэжлийн сургалтын байгууллагуудын мэдээллийн шинэчлэлтийг улирал тутам хийнэ.

6.4 МБСУМАЗТ нь мэргэжлийн сургалтын үйл ажиллагааны талаарх тайланг хагас, бүтэн жилээр гарган, холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.

---o0o---

ТӨСӨӨЛ